ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ СЭДЭВТ НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1 СЭДВИЙН ЗОРИЛГО

"Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл" сэдэвт аудитын хүрээнд дүгнэлт, зөвлөмж боловсруулж, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах.

2 ХАМРАХ ХҮРЭЭ

- ☑ Говьсүмбэр аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс
- ☑ Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын Санхүүгийн алба
- ☑ Төрийн сангийн удирдлагын цахим системийг ашигладаг төрийн байгууллагууд
- ☑ 2023–2025 оны үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, төлөвлөгөө, тайлан, санхүүгийн баримт, мэдээлэл

3 АУДИТЫН АСУУДЛЫН ХҮРЭЭ

1. Төрийн сангийн тогтолцоо, оновчтой бүрдсэн эсэх
2. Төрийн сангийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

ОРОН НУТГИЙН ТӨРИЙН САНГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН НИЙТ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

01 АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС	02 СҮМБЭР СУМЫН САНХҮҮГИЙН АЛБА	03 ШИВЭЭГОВЬ СУМЫН САНХҮҮГИЙН АЛБА	04 БАЯНТАЛ СУМЫН САНХҮҮГИЙН АЛБА
Батлагдсан орон тоо: 6	Батлагдсан орон тоо: 2	Батлагдсан орон тоо: 2	Батлагдсан орон тоо: 2
Ажиллаж буй: 5	Ажиллаж буй: 2	Ажиллаж буй: 1	Ажиллаж буй: 2
Дутуу орон тоо: 1	Дутуу орон тоо: 0	Дутуу орон тоо: 1	Дутуу орон тоо: 0

ХҮНИЙ НӨӨЦИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

12	10	2	14	1
НИЙТ БАТЛАГДСАН ОРОН ТОО (АЙМАГ + 3 СУМ)	НИЙТ АЖИЛЛАЖ БАЙГАА АЛБАН ХААГЧ	ДУТУУ ОРОН ТОО (АЙМАГ – 1, ШИВЭЭГОВЬ – 1)	2023–2025 ОНД МЭРГЭЖЛИЙГЭН 14 УДАА СОЛИГДСОН	ЧИГ ҮҮРЭГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ХААГЧ

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ СЭДЭВТ НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО

- ☑ Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн сангийн бүтэц, зохион байгуулалт нь Төсвийн тухай хуулийн шаардлагад нийцээгүй байна.
- ☑ Аймгийн СТСХ болон сумдын санхүүгийн албанд хуний нөөцийн тогтвор суурьшил хангалттүй, сумдын түвшинд шаардлага, шалгуур хангасан мэргэшсэн хүний нөөц хүрэлцээгүй байна.

ДҮГНЭЛТ

Орон нутагт төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдээгүй, дотоод хяналт үр нөлөөгүй байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ☑ Орон нутгийн орлогын бүрдүүлэлт хангалттүй байснаас төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжилтийг бүрэн, хугацаанд нь олгох боломж бүрдээгүй байна.
- ☑ Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа бөгөөд зарцуулалтын эрх олголт, төлбөр тооцоотой холбоотой нийтлэг зөрчлүүд давтан илэрч байна.
- ☑ Аймаг, сумдын төрийн сангууд төлбөр тооцооны хяналтын явцда санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлтийн зөрчлийг янз бүрээр тайлбарлан, ялгаатай байдлаар хэрэгжүүлж байна.
- ☑ Аймгийн СТСХ, сумдын Санхүүгийн албанд төлөвлөгөөт хяналт хэрэгжиж байгаа боловч нийтлэг зөрчил, дутагдал илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байгаа нь дотоод хяналтын үр нөлөө хангалттүй байгааг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа боловч санхүүжилт, зарцуулалтын эрх олголт, төлбөр тооцоотой холбоотой нийтлэг зөрчлүүд давтагдаж байна.

АУДИТААР НИЙТ 546.4 САЯ ТӨГРӨГИЙН ЗӨРЧИЛ ИЛЭРЧ,

- аймгийн СТСХ-д 233.9 сая төгрөгийн 2 албан шаардлага,
- 129.6 сая төгрөгийн 5 зөвлөмж,
- сумдын Санхүүгийн албанд 145.6 сая төгрөгийн 6 албан шаардлага,
- 37.3 сая төгрөгийн 8 зөвлөмж хүргүүлсэн.